

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЗАХИРЛЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТУХАЙ ЗАР

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус эмнэлгийн Захирлын албан тушаалд нээлттэй сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд мэдээлж байна.

Сонгон шалгаруулалтыг Эрүүл мэндийн сайдын 2021 оны A/414 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчтөй төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг сонгон шалгаруулах журам”-д заасны дагуу зохион байгуулна.

Журмыг <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230721626331&showType=1> энд дарж үзнэ үү./

Нэг. Тавигдах шаардлага

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг болон Албан тушаалын тодорхойлолтод заасны дагуу эмнэлгийн захирлын албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцох иргэн дараах шаардлагыг хангасан байна.

1. Эрүүл мэндийн салбарт 10-аас доошгүй жил ажилласан байх;
2. Эрүүл мэндийн байгууллагад 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан байх;
3. Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль төгссөн байх, /баклавраас дээш боловсролын зэрэгтэй бол давуу тал болно/;
4. Эрүүл мэндийн удирдлагаар мэргэшсэн байх;
5. Тодорхой албан тушаал эрхлэх буюу үйл ажиллагаа явуулах эрх нь шүүхийн шийдвэрээр хасагдаагүй байх;
6. Улс төрийн намын гишүүн бус байх;
7. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад удирдах албан тушаал эрхэлдэгтүй байх;
8. Бусад байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагын бүрэлдэхүүнд хавсран ажилладаггүй байх.

Хоёр. Сонгон шалгаруулалтад оролцоход бүрдүүлэх баримт бичиг

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй, шаардлага хангасан иргэн доор дурдсан баримт бичгийг бүрдүүлж өгнө.

2.1. Төрийн албан хаагчийн анкет (Төрийн албаны зөвлөлөөс баталсан маягтын дагуу);

2.2. Иргэний үнэмлэхний хуулбар эсхүл улсын бүртгэлийн лавлагаа;

2.3. Тухайн албан тушаалд томилогдох хүсэлт, бүрдүүлсэн баримт бичгийн үнэн болохыг илэрхийлсэн өргөдөл;

2.4. Тухайн иргэний мэргэжлийн мэдлэг, ур чадвар, туршлагыг баталгаажуулсан 2 хүний тодорхойолт (өмнө нь ажиллаж байсан эсхүл одоо харьялж буй байгууллагын дарга/захирал, тухайн иргэний гишүүнчлэлтэй мэргэжлийн нийгэмлэг, холбооны удирдах зөвлөл эсхүл гүйцэтгэх захирлын);

2.5. Цээж зураг (4x3 хэмжээтэй 2 хувь);

2.6. Анааах ухааны боловсрол олгох их, дээд сургууль төгссөн, эрүүл мэндийн удирдлагаар мэргэшсэнийг нотлох баримт бичиг (боловсролын диплом, мэргэшлийн үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, эх хувийн хамт);

2.7. Эрүүл мэндийн салбарт 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт бичиг (хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн холбогдох хэсгийг хуулбарлан эх хувийн хамт);

2.8. Эрүүл мэндийн байгууллагад 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласныг нотлох баримт бичиг (хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн холбогдох хэсгийг хуулбарлан эх хувийн хамт);

2.9. Англи хэлний мэдлэгийн түвшинг тодорхойлох баримт бичиг / хуулбар, эх хувийн хамт);

2.10. Тухайн эмнэлгийг хөгжүүлэх төсөл (хагас бие даан хөгжүүлэх бодлого, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, санхүү, тусламж, үйлчилгээний төлөвлөлт, хүрэх үр дүн, үр ашиг г.м);

2.11. Улс төрийн намын гишүүн бус, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад удирдах албан тушаал эрхэлдэгтүй, бусад байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагын бүрэлдэхүүнд хавсрان ажилладаггүйг илэрхийлж бичсэн баталгаа;

2.12. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн талаарх лавлагaa;

2.13. Нийтийн албанад томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг.

Гурав. Сонгон шалгаруулалтын баримт бичиг хүлээн авах, бүртгэл явагдах хугацаа.

Баримт бичгийг цаасан болон цахимаар /баримт бичгийн дарааллаар PDF болгож DVD-д хуулбарлан/ бүрдүүлж ирүүлнэ. Бүрдүүлсэн баримт бичиг болон баримт бичгийн жагсаалт, тус бүрийн хуудасны тоог дурдаж өөрийн гарын үсэг зурсан товъёогийг дугтуйнд хамт хийж битүүмжлэн 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 18:00 цагаас өмнө Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгч бүртгүүлнэ.

“Төрийн болон орон нутгийн өмчтэй төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг сонгон шалгаруулах журам”-ын 5.6-д заасны дагуу Баримт бичгийг хүлээн авч, бүртгэхтэй холбоотой гомдолыг ажлын 1 өдрийн дотор хүлээн авна.

Дөрөв. Хариуцах ажилтан:

Баримт бичиг болон гомдлыг Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 231 тоот өрөөнд Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хүлээн авна.

Холбоо барих утас:99038144, 80043003

Жич: Эх хувиар ирүүлсэн баримт бичгийг сонгон шалгаруулалт дууссаны дараа буцаан өгнө.

**НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**